



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР
АЖЛААС ХАЛСНЫ УЛМААС ТӨРД УЧРУУЛСАН ХОХИРЛЫГ НӨХӨН
ТӨЛӨХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 цахим хуудас:
Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 цахим хуудас: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хуудас: erbolu@audit.gov.mn

Аудитор Б.Үүрийнтуяа

Утас: 89838414 Цахим хуудас: uuriintuyab@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

**“Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсны улмаас төрд
учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргийн хэрэгжилт”-ийг
шалгасан тухай аудитын танилцуулга**

2021.11.29

Өлгий сум

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д “Төрийн аудитын байгууллага тухайн жилд Захиргааны ерөнхий хуулийн 103.3-т заасны дагуу төрийн албан тушаалтны төрд учруулсан хохирлыг төлүүлэх үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг жил бүр Үндэсний аудитын газрын цахим хуудсанд байршуулна” гэж заасны дагуу төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргийн хэрэгжилтийг аудитор У.Ербол, Б.Үүрийнтуяа бид нар 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны хооронд шалгасан болно.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасан.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан Төсвийн ерөнхийлөн захирагч буюу аймгийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын алба юм. Төсвийн тухай хуулийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэж заасан учраас аймгийн Засаг даргаас бусад Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын албан тушаалтнуудын төрд учруулсан хохирлыг Санхүүгийн хяналт, аудитын алба хариуцан төлүүлэх үүрэгтэй байдаг.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газраас төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргийн хэрэгжүүлэхтэй холбоотой Санхүүгийн хяналт, аудитын албад дараах шийдвэрүүдийг хүргүүлсэн байна.Үүнд:

1.Тус аудитын газраас төсөвт байгууллагуудын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 2019 онд хийсэн баталгаажуулах аудитаар байгууллагын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан 33 хүнтэй холбоотой 105.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар албан шаардлага хүргүүлсэн.

2.Төсөвт байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 2020 онд хийсэн баталгаажуулах аудитаар байгууллагын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан 16 хүнтэй холбоотой 60.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар албан шаардлага хүргүүлсэн.

3. Төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд 2021 онд хийсэн баталгаажуулах аудитаар байгууллагын төсвөөс зориулалт бусаар зарцуулсан 5 хүнтэй холбоотой 32.7 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэх талаар албан бичиг хүргүүлсэн байна.

4. Тус аудитын газраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагаанд 2020 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 70 хүнтэй холбоотой 333.5 сая төгрөгийн хохирлын нөхөн төлбөрийн судалгааг гаргаж, холбогдох нотлох баримтуудыг харьяаллын дагуу Санхүүгийн хяналт, аудитын албанд шилжүүлжээ.

Харин аймгийн Засаг даргатай холбоотой хууль бус ажлаар халагдсан 13 хүнтэй холбоотой 135.4 сая төгрөгийн хохирлын судалгааг нотлох баримтын хамт харьяаллын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дотоод аудитын албанд шилжүүлэхээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас аймаг дахь Төрийн аудитын газраас хүргүүлсэн албан шаардлагын хэрэгжилтийн талаар:

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 58 дугаар албан бичгээр 83 хүнтэй холбоотой 435.3 сая төгрөгийн төрд учруулсан хохирлын биелэлтийг тус газарт ирүүлжээ.

Дээрх судалгааг нэг бүрчлэн дугаарлаж, нэгтгэж хянаж үзэхэд 8 хүний нэр, шүүхийн шийдвэрийн дугаар, төлбөрийн дүн давхардсаныг хасаж тооцоход 78 хүнтэй холбоотой 395.6 сая төгрөгийн төрд учруулсан хохирлын жагсаалт байна.

Хүснэгт №1

/ сая төгрөгөөр/

№	Аудитын төрөл	ТАХ-ыг хууль бус ажлаас чөлөөлсөн, халсны улмаас төрд учруулсан хохирлын хэмжээ		СХАА-наас ирүүлсэн биелэлт	хувь
		хүний тоо	төлбөрийн дүн		
1	2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар	32	112.3	78 хүнтэй холбоотой 395.6 сая төгрөгийн хохирлын биелэлтийг ирүүлсэн	
2	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар	16	60.3		
3	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар	5	32.7		
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар	70	333.5		
Нийт дүн		123	538.8		

Дээрхи 78 хүнтэй холбоотой 395.6 сая төгрөгийн төрд учруулсан хохирлын барагдалтыг шалгаж үзэхэд:

- 19 хүнтэй холбоотой 152.8 сая төгрөгийн хохирлыг тухайн салбар хариуцсан дотоод аудитын нэгж хариуцахаар,
- 17 хүнтэй холбоотой 71.5 сая төгрөгийн хохирол нь биелэгдээгүй,
- 8 хүнтэй холбоотой 34.6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон,

- 6 хүнтэй холбоотой 25.7 сая төгрөгийн хохирлын хариуг тухайн шатны шүүхээс ирүүлээгүй,
- 6 хүнтэй холбоотой 19.3 сая төгрөгийн хохирол нь хууль батлагдахаас өмнө гарсан,
- 3 хүнтэй холбоотой 19.2 сая төгрөгийн хохирлыг Прокурор хүчингүй болгосон,
- 7 хүнтэй холбоотой 18.7 сая төгрөгийн хохирлыг Прокурорын газарт шилжүүлсэн,
- 5 хүнтэй холбоотой 13.3 сая төгрөгийн хохирлыг Улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр хүчингүй болгосон,
- 2 хүнтэй холбоотой 11.9 сая төгрөгийн хохирлыг Төрийн аудитын газарт буцаасан,
- 1 хүнтэй холбоотой 11.3 сая төгрөгийн хохирлыг сумын ИТХ-аас шийдвэр гаргасан тул биелүүлэх боломжгүй,
- 1 хүнтэй холбоотой 10.2 сая төгрөгийн хохирлыг шүүхийн шийдвэрээр төлөхөөр болсон,
- 1 хүнтэй холбоотой 3.7 сая төгрөгийн хохирол Сангийн яамд хянагдаж байгаа,
- 1 хүнтэй холбоотой 3.3 сая төгрөгийн хохирлыг шүүхээс хүчингүй болгосон гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус аудитын газраас 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ирүүлсэн 53 дугаар албан бичигт “ ... зарим албан тушаалтнуудад акт тогтоох асуудал манай албаны хариуцлага хүлээлгэх эрх хэмжээнд харьяалагдахгүй өөр Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний байгууллагууд тул акт тогтоох боломжгүй байна. Иймд хавсралтад байгаа 7 төсвийн байгууллагын удирдах албан тушаалтантай холбоотой 19 хүний хүний 164.3 сая төгрөгийн хохирлыг буцааж байна” гэсэн байна.

Аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 509 дүгээр албан бичгээр дээрх албан бичигт дурдсан асуудал нь үндэслэлгүй байгаа тул хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг чиглэл болгож хариу хүргүүлжээ.

Гэтэл тус албанаас 11 дүгээр сарын 19-ний өдрийн 58 дугаар албан бичигт Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Өлгий сумын Ерөнхий боловсролын лаборатори 2, 3 дугаар сургууль, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 19 хүнтэй холбоотой 152.8 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг “тухайн салбар хариуцсан дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн тайлбартайгаар дахин ирүүлсэн байна.

Санхүүгийн хяналт аудитын алба нь дээрх 19 хүнтэй холбоотой 152.8 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг төлүүлэхээс үндэслэлгүй татгалзаж, хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаагийн дээр 17 хүнтэй холбоотой 71.5 сая

төгрөгийн хохирлыг төлүүлэх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй байгааг албан үүргээ хэрэгжүүлэхээс үндэслэлгүй татгалзаж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Дээрх судалгаанд 8 хүнтэй холбоотой 34.6 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон, 6 хүнтэй холбоотой 25.7 сая төгрөгийн хохирлын хариуг шүүхээс ирүүлээгүй, 3 хүнтэй холбоотой 19.2 сая төгрөгийн хохирлыг Прокурор хүчингүй болгосон, 5 хүнтэй холбоотой 13.3 сая төгрөгийн хохирлыг Улсын ерөнхий байцаагч хүчингүй болгосон, 1 хүнтэй холбоотой 3.3 сая төгрөгийн хохирлыг шүүхээс хүчингүй болгосон, 1 хүнтэй холбоотой 10.2 сая төгрөгийн хохирлыг шүүхийн шийдвэрээр төлөхөөр болсон, 1 хүнтэй холбоотой 3.7 сая төгрөгийн хохирлыг Сангийн яам хянаж байгаа гэсэн тайлбар ирүүлсэн боловч нотлох баримт хавсаргаж ирүүлээгүй байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.4-т "Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй" гэсэн заалттай боловч тус алба нь төрд учирсан хохирлын шийдвэрлэлтийн талаар хуулийн байгууллагуудаас гарсан холбогдох шийдвэрүүдийг баримтжуулж авах талаар санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Мөн Орон нутгийн өмчийн алба, Ногооннуур сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГ, Өлгий сумын 10, 18 дугаар цэцэрлэг зэрэг 5 байгууллагын 6 хүнтэй холбоотой 19.3 сая төгрөгийн хохирол нь хууль батлагдахаас өмнө гарсан гэх боловч нотлох баримтгүй байна. Энэхүү 19.3 сая төгрөгийн хохирол нь Захиргааны ерөнхий хууль батлагдахаас өмнө гарсныг нотлох баримтуудыг ирүүлж албан шаардлагын дүнгээс хасуулах нь зүйтэй байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал, Бугат сумын Засаг дарга, Алтанцөгц сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын асуудалтай холбоотой 23,1 сая төгрөгийн хохирол нь хууль батлагдахаас өмнө гарсан шийдвэр, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн гаргасан хамтын шийдвэр учраас буруутай албан тушаалтныг тогтоох боломжгүй тул албан шаардлагын дүнгээс хасах нь зүйтэй байна.

Бугат, Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газар, Өлгий сумын 16,18 дугаар цэцэрлэгийн 7 хүнтэй холбоотой 18.7 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч төлбөрийн акт тогтоож, албан бичгээр аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн байна.

Прокурорын газарт шилжүүлсэн 7 төлбөрийн актын үндэслэлийг судалж үзэхэд шалгалтын танилцуулга бичээгүй, шалгалтын тэмдэглэл хөтөлж баримтжуулаагүй, акт тогтоох журмыг мөрдөж ажиллаагүй, актын тэмдэглэх хэсэгт шүүхийн шийдвэрийг үндэслэлгүй зөвхөн Захиргааны ерөнхий хуулийг дурдсан, төлбөрийн актад төлбөр хариуцагч нь гарын үсэг зураагүй, татгалзсан бол тайлбар аваагүй, төлбөр хариуцагчид мэдэгдэж, сонсох ажиллагаа явуулаагүй, нотлох баримтуудыг зохих журмаар бүрдүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.4, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 6.3.1, 6.3.2, 6.3.3, 7.5, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт"-ын 3.2.8, 3.4-ийн 9 дэх заалтуудтай

нийцэхгүй байгаа тул улсын байцаагчийн тогтоосон акт нь бүхэлдээ хүчингүй болох магадлалтай байна.

Аймгийн Прокурорын газрын 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 01/478 дугаар албан бичгээр 44 удаагийн 272.6 сая төгрөгийн хохиролтой холбоотой нотлох баримт ирүүлэхийг тус албанд чиглэл болгосон байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 21 дүгээр албан бичгээр төрийг хохироосон удирдах албан тушаалтантай холбоотой 44 удаагийн 272.6 сая төгрөгийн хохирлын судалгааг холбогдох нотлох баримтын хамт аймгийн Прокурорын газарт хүргүүлсэн байна.

Тус албанд ирүүлсэн Аймгийн Прокурорын газрын 2021 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 01/636 дугаар албан бичигт төлбөрийн акт тавигдсан 5 актаас бусад баримт материалыг акт тавигдаагүй, нотлох баримт цуглуулаагүй гэсэн үндэслэлээр буцааж, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь заалтыг баримталж ажиллах талаар зөвлөсөн байна.

Аудитын явцад төсөвт байгууллагуудын 2017-2020 оны санхүүгийн тайланд тус аудитын газраас итгэл үзүүлсэн 92 байгууллагуудын нягтлан бодогч нартай утсаар холбогдож хууль бус ажлаас чөлөөлсөн, халсны улмаас төрд учруулсан хохирол байгаа эсэхийг тодруулан асууж баримтжуулав.

Судалгаагаар хууль бус ажлаас халагдсан аймгийн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, Татварын хэлтэс, “Мейрим” өрхийн эмнэлгийн удирдах албан тушаалтнуудтай холбоотой 3 хүний 21,7 сая төгрөгийн хохирлыг харьяаллын дагуу дотоод аудитын албад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Мөн үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албан бичиг хүргүүлж өмнөх онд гүйцэтгэлийн аудит хийгдсэнээс хойших буюу 2020 оны 10 дугаар сарын 01-ээс 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд ажлаас үндэслэлгүй халагдаж, ажилдаа эргүүлэн томилогдож төрөөс хохирлыг барагдуулсан талаарх судалгааг шүүхийн шийдвэр, бусад нотлох баримтуудын хамт гаргуулж авсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 11 удирдах албан тушаалтантай холбоотой 95.3 сая төгрөгийн хохирлын судалгааг нотлох баримтуудын хамт ирүүлсэн болно.

Үүнээс Алтанцөгц, Ногооннуур сумын ИТХ-ын дарга, Бугат сумын Засаг даргатай холбоотой 37.7 сая төгрөгийн хохирол нь тухайн сумын ИТХ-ын төлөөлөгч нарын хамтын шийдвэрээр хэрэгжсэн, Бугат сумын Эрүүл мэндийн төвийн даргатай холбоотой 3.7 сая төгрөгийн хохирол нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитаар Санхүүгийн хяналт, аудитын албанд шилжүүлсэн, Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн ажилтантай холбоотой 15.6 сая төгрөгийн хохирол нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын гүйцэтгэх ажлаар бүрэн төлөгдөөгүй, тухайн байгууллагад мэдэгдэл хүргүүлсэн байна.

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Өлгий сумын Засаг даргын Тамгын газар, Гэр бүл Хүүхэд залуучуудын газар, аймгийн Хөгжимт драмын театрын 5 удирдах албан

тушаалтантай холбоотой 38.3 сая төгрөгийн хохирлыг харьяаллын дагуу Санхүүгийн хяналт, аудитын албанд шилжүүлэхээр болов.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2017-2019 оны үйл ажиллагаанд 2020 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргатай холбоотой 13 хүний 135.4 сая төгрөгийн төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх албан бичгийг нотлох баримттай хамт Үндэсний аудитын газарт хүргүүлсэн бөгөөд Үндэсний аудитын газар дээрх 13 хүнтэй холбоотой нотлох баримт бичгийг /дээд шатны дотоод аудитын нэгжид болох/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд даргад 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/426 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн ХЭГ/625 дугаар албан бичгээр дээрх асуудлыг тус аймгийн Засаг даргад ирүүлж төлүүлэх арга хэмжээ авах чиглэл өгсөн байна. Аймгийн Засаг дарга 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 1-01/1747 дугаар албан бичгээр дээрх нотлох баримтуудыг тайлбарын хамт тус аудитын газарт ирүүлсэн болно.

Энэхүү аймгийн Засаг даргатай холбоотой 13 хүний 135.4 сая төгрөгийн төрд учруулсан хохиролтой холбоотой нотлох баримт, материалыг аудитын явцад аймгийн Прокурорын газарт шилжүүлэв.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2, 103.4 дэх заалтуудын дагуу төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Р.Хуатханд:

Төрийн албан хаагчийг үндэслэлгүй ажлаас халсны улмаас төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар санаачилга гарган тодорхой арга хэмжээ авч ажиллан Захиргааны ерөнхий хуулийн 103.2-т заасан албан үүргээ биелүүлж ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

АУДИТОР

У.ЕРБОЛ

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА